



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.06 № 03/2066

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102627 дугаартай "Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	Багц-5 Дүрс оношилгооны тоног төхөөрөмж Суурин рентген аппарат 1ширхэг Техник үзүүлэлтэд байх удирдлагын хэсэгт тог баригчтай байх гэсэн үзүүлэлт нь яг аль хэсгийн ямар төхөөрөмжид шаардлагатай гэж үзэж байна? (Рентген операторын өрөөний компьютер болон принтер эсвэл тоног төхөөрөмж аппараттай хамт ашиглагдах) Рентген аппараттай хамт ашиглагдах хүчдэл тогтворжуулагч байхгүй байгааг тодруулж өгнө үү? Принтертэй гэсэн үзүүлэлтийг илүү дэлгэрэнгүй мэдээллээр хангана уу? Ямар төрлийн принтер шаардлагатай вэ?	Рентген операторын өрөөний компьютерт ашиглах тог баригчтай байх. Мөн тухайн аппаратад тохирсон АУК буюу хүчдэл тогтворжуулагч тус тусдаа байна. Dicom болон Фото принтер аль аль нь холбогддог байх ба dicom буюу хальсан дээр хэвлэгддэг принтер дагалдсан байх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.